



**МОНГОЛ УЛСЫН
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**

**МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧДАД
ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА**

/Шинэчилсэн 3 дахь хэвлэл/

УЛААНБААТАР ХОТ
2016 он

МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

Гарын авлага боловсруулсан:

Ц.БААСАНДЭЛГЭР Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт,
дүн шинжилгээний хэлтсийн ахлах
ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэгч,
комиссар

Хянасан:

Ц.ЦЭЦЭГДЭЛГЭРЭХ Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт,
дүн шинжилгээний хэлтсийн албаны дарга,
ахлах комиссар

Офсет хэвлэл

Цаасны хэмжээ: А6 /105мм*148мм/

Хэвлэлийн хуудас:

Хэвлэсэн тоо:

Хэвлэсэн газар: “УРАНГАР ПРЕСС” ХХК



ГАРЧИГ

1. Мэдүүлэг гаргагчийн тухай ойлголт4
2. Мэдүүлэг гаргах харьяалал5
3. Мэдүүлэг гаргагчийн үүрэг8
4. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах11
5. Хариуцлага хүлээлгэх үндэслэл13
6. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахимаар мэдүүлж, цаасаар бүртгүүлэх заавар15
 - А. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахимаар мэдүүлэх тухай 15
 - Б. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргахад анхаарах зарим асуудал18
7. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргах ...20
8. Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх асуудлаар мэдэгдэл, тайлбар гаргах21
9. ХАСХОМ, ХАСУМ, Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх асуудлаар мэдэгдэл, тайлбар гаргасан загвар жишээ ..23



НЭГ. МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу дор дурдсан этгээд хуулийн үйлчлэлд хамаарна.

- төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;
- төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;
- төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;
- олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;
- улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;
- бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;
- эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан.



ХОЁР. МЭДҮҮЛЭГ ГАРГАХ ХАРЬАЛАЛ

Авлигатай тэмцэх газарт: Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 2.1-д заасан албан тушаалтан;

Шүүхийн ерөнхий зөвлөлд: Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч;

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд: Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;

Улсын Их Хурлын Тамгын газарт: Төрийн улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх;

Засгийн газрын хэрэг эрхлэх газарт: Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;

Сангийн яаманд /хуучнаар Төрийн өмчийн хороо/: Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, банк, санхүүгийн байгууллага, биржийн удирдах албан тушаалтан, Монгол Улсаас бусад улстай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээгээр үйл ажиллагаа нь зохицуулагдаж байгаа төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан; /эдгээр хуулийн этгээдийн удирдах албан тушаалд ажиллаж байгаа гадаадын иргэн нэгэн адил хамаарна/.



Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд: Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч, ажлын албаны ажилтан, Засаг дарга, Засаг даргын орлогч;

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт: Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргаас томилогддог төрийн захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн захирал;

Мэдүүлэг гаргагчийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд:

1. Хуулийн үйлчлэлд хамрагдах нийтийн албан тушаалтан болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалтад орсон албан тушаалтан, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2 дахь заалтад дурдагдсан албан тушаалтан;
2. Төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагч, төрийн үйлчилгээний албаны дарга, захирал, эрхлэгч, тэдгээртэй адилтгах албан тушаалтан түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд;
3. Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор улсын нэгдсэн төсвөөс төвлөрүүлсэн хөрөнгө, түүнчлэн уг арга хэмжээнд



зориулан олгосон хандив, буцалтгүй тусламжийг захиран зарцуулж байгаа Засгийн газрын тусгай сангийн удирдах албан тушаалтан түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд /Олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу зээл, тусламж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн зохицуулагч, удирдах албан тушаалтан нэгэн адил хамаарна/;

4. Эрдэм шинжилгээ, инноваци, туршилт, зохион бүтээх ажлыг дагнан болон сургалт, үйлдвэрлэлтэй хослон гүйцэтгэдэг эрдэм шинжилгээний байгууллагын удирдах албан тушаалтан түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд;
5. Яам, агентлагийн дэргэдэх өөрийгөө санхүүжүүлдэг салбар нэгжийн удирдах албан тушаалтан харьяа байгууллагын түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд;
6. Төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежертэй гэрээ байгуулж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан тухайн төсвийн захирагчид /ерөнхий менежерт/;
7. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч Сонгуулийн ерөнхий хороонд, орон нутгийн сонгууль /аймаг, нийслэл, сум, дүүрэг/-д нэр дэвшигч нь тухайн орон нутгийн сонгуулийн хороонд.



ГУРАВ. МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ

Хуульд заасан хугацаанд гаргаж өгөх

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т зааснаар мэдүүлгээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байх хугацаандаа жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.

Дээр дурдсан хугацаанд мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаангүй бол Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.5, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэгт тус тус зааснаар гаргаж өгөөгүйд тооцно.





Мэдүүлэг гаргагч нь хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /цаашид “ХАСХОМ” гэх/-ээ эрх бүхий албан тушаалтан /цаашид “ЭБАТ” гэх/-д хүлээлгэн өгөхдөө ХАСХОМ хүлээн авсан тухай бүртгэл”-ийн дэвтэрт гарын үсгээ зурах үүрэгтэй.

Хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлтийн тухай мэдэгдэх

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т зааснаар мэдүүлэг гаргагч энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол өөрчлөлт орсноос хойш 30 хоногийн дотор мэдүүлж бүртгүүлнэ.

Их хэмжээний өөрчлөлтийг цахимаар мэдүүлэхдээ “мэдүүлэг гаргах үндэслэл”-ийг сонгож зөвхөн өөрчлөлт орсон хөрөнгө, орлогыг мэдүүлнэ. Тодруулбал, “Хөрөнгө, орлогод орсон их хэмжээ” гэдэгт Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны хамтарсан шийдвэрийн дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2013 оны 09 дүгээр 01-ний өдрөөс эхлэн 192000 төгрөг байгаа нь 48 сая төгрөг түүнээс дээш, харин 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 240000 төгрөг болсон нь 60 сая төгрөг түүнээс дээшхи хэмжээг тус тус ойлгоно.

Бодитой, үнэн зөв мэдүүлэх

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т зааснаар мэдүүлэг гаргагч нь өөрийн хувийн ашиг сонирхол, түүнчлэн өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.



Хөрөнгө, орлогын эх үүсвэрийн талаар болон хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг тодорхой тайлбарлах

Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.8-д зааснаар мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын эх үүсвэрийг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бодитой, үнэн зөв тайлбарлах үүрэгтэй. Хөрөнгө, орлого, зээлийг мэдүүлэхдээ УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 4 дэх хэсгийн 4.4 дэх хэсэгт заасныг баримтална.

Батлагдсан маягтын дагуу засваргүй, тодорхой бичих, асуулт бүрт хариулах

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 4 дэх хэсгийн 4.5 дахь хэсэгт зааснаар мэдүүлэг гаргагч мэдүүлгийг засваргүй, тодорхой, ойлгомжтой бичих бөгөөд асуулт бүрт хариулна.



ДӨРӨВ. ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ ХЯНАН ШАЛГАХ

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах үндэслэлийг Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлд дараах байдлаар тогтоосон. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын гишүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг иргэний өргөдөл, гомдолд үндэслэн Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо;
- Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол тухайн гишүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар;
- Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг өргөдөл, гомдолд үндэслэн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо;
- Бусад албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар тус тус хянан шалгана.

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, 13.4, 13.5, 13.6 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4, 26.5, 26.6 дахь хэсэгт тус тус заасны дагуу дараах үндэслэлээр хянан шалгана. Үүнд:



1. Мэдүүлгээ хуульд заасан хугацаанд нь гаргаж өгөөгүй;
2. Хөрөнгө, орлогын эх үүсвэрийг заагаагүй буюу түүнийг хэрхэн олсон талаар тайлбар гаргаагүй;
3. Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүрэн гүйцэд гаргаагүй;
4. Өргөдөл, гомдол, мэдээллийн мөрөөр;
5. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дагуу.



ТАВ. ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ҮНДЭСЛЭЛ

1. Мэдүүлэг гаргагч **Хөрөнгө, орлогын мэдүүлгээ** хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй, худал мэдүүлсэн бол түүнд Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8 дахь хэсэгт заасны дагуу дараах хариуцлага хүлээлгэнэ. Үүнд:
 - **Сануулах.** Нэг сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн, хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигын эсрэг хуулийн 10.4, 10.5-д заасан хугацаанаас хожимдуулсан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол;
 - **Албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах.** Зургаа хүртэл сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн, хөрөнгө, орлогын мэдүүлгээ удаа дараа хугацаа хожимдуулж гаргасан;
 - **Албан тушаал бууруулах, эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах.** Зургаан сараас дээш нэг жил хүртэлх хугацааны цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол;
 - **Албан тушаалаас нь огцруулах буюу ажлаас халах.** Нэг жилийн цалин хөлстэй тэнцэх буюу түүнээс их хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй, худал мэдүүлсэн, эсхүл хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан.
2. Мэдүүлэг гаргагч **Хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ** хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй, худал мэдүүлсэн бол түүнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг



сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасны дагуу дараах сахилгын шийтгэл хүлээлгэнэ. Үүнд:

- Хугацаанаас хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол **сануулах**
 - Удаа дараа хожимдуулж гаргасан бол **албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;**
 - Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2 дахь хэсэгт заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан болон худал мэдүүлсэн бол **албан тушаал бууруулах**
 - Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.3 дахь хэсэгт заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан болон гаргаж өгөөгүй бол нийтийн албанаас халах сахилгын шийтгэл тус тус ногдуулна.
3. Нийтийн албанд илтэд ашиг сонирхлын зөрчилтэй нь тогтоогдсон этгээдийг нэр дэвшүүлж томилсон удирдах албан тушаалтныг дээд шатны албан тушаалтнаас албан тушаалыг нь бууруулах сахилгын шийтгэл ногдуулна.
4. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих үүргээ биелүүлээгүй, эсхүл холбогдох материалыг Авлигын эсрэг хуулийн 10.3- т заасан хугацаанд ирүүлээгүй албан тушаалтныг эрх бүхий байгууллага, албан тушаалтан албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, уг зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулна.




ЗУРГАА. ХАСХОМ-ИЙГ ЦАХИМААР МЭДҮҮЛЖ, ЦААСААР БҮРТГҮҮЛЭХ ЗААВАР

Мэдүүлэг гаргагч нь хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ хуульд заасан хугацаанд цахимаар мэдүүлж, цаасан хэлбэрээр бүртгүүлнэ.

А. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахимаар мэдүүлэх тухай

Хуулийн дагуу мэдүүлэг гаргах үүрэгтэй нийтийн албан тушаалтан нь хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ <https://meduuleg.iaac.mn> сайтад нэвтрэн, цахимаар мэдүүлнэ. Үүнд:



1. Мэдүүлэг гаргагч анх удаа цахим хэлбэрээр мэдүүлгээ гаргах гэж байгаа бол тухайн байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан /цаашид ЭБАТ гэх/-аас мэдүүлэг гаргагчийн товч бүртгэл /тайлант он, албан тушаалын нэр, регистрын дугаар, и-мэйл хаяг, байгууллага, албан тушаал, мэдүүлэг гаргах үндэслэл/-ийг цахим системд оруулж бүртгэнэ. /мэдүүлэг гаргагчийн албан тушаалыг уг систем дэх албан тушаалын нэрийн сонголтоос сонгоно/.
2. Харин мэдүүлэг гаргагч өмнө нь өөр байгууллагад цахимаар мэдүүлгээ бүртгүүлж байсан бол өмнө нь ажиллаж байгууллагын ЭБАТ-аас уг мэдүүлэг гаргагчийн шинэчлэн гаргасан мэдүүлэгт “хасалт хийж”, дараагийн томилогдон ажиллах байгууллагын ЭБАТ-аас “шилжүүлэн татаж авна”. /Шилжүүлэн татаж авахдаа хасалт хийгдсэн тухайн оных нь ХАСХОМ-ийн товч мэдээллийг оруулна/.



3. ЭБАТ-аас цахим системд мэдүүлгийг бүртгэсэн эсхүл мэдүүлгийг шилжүүлэн авсны дараа мэдүүлэг гаргагч нь <https://meduuleg.iaac.mn> системд нэвтрэх нууц үгийг “НУУЦ ҮГ СЭРГЭЭХ ХОЛБООС” хэсгээс шинээр авч, нэвтэрнэ. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмд нэвтрэх нэр нь тухайн мэдүүлэг гаргагчийн цахим системд бүртгүүлсэн и-мэйл хаяг байна.
4. Нууц үгээ сэргээхэд “Нэвтрэх форм”-ын “Нууц үг сэргээх холбоос” товчийг дарж, цахимд бүртгэлтэй и-мэйл хаягаа оруулан, дараа нь “Илгээх” товчийг дарснаар таны и-мэйл хаягт мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмд нэвтрэх нууц үг сэргээгдэж очно.

Нэвтрэх форм

Secured by Othawto 2014-03-18

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн програм

Нэвтрэх нэр

Нууц үг

[Нууц үг сэргээх холбоос](#)

[Тусламж](#)

5. Мэдүүлэг гаргагч и-мэйл рүү нь ирсэн нууц үгийг ашиглан <https://meduuleg.iaac.mn> цахим системд нэвтрэж, ХАСХОМ-ийн мэдээллээ бүрэн оруулж, хэвлэн, гарын үсгээ зурна.
6. Мэдүүлгээ тухайн байгууллагын ЭБАТ-д хүлээлгэн өгөхдөө “ХАСХОМ-ийг хүлээн авсан тухай бүртгэл”-ийн дэвтэрт гарын үсэг зурж, хүлээлгэн өгнө.
7. Мэдүүлгийг хүлээн авсан байгууллагын ЭБАТ нь ХАСХОМ-ийг <https://meduuleg.iaac.mn> сайтад цахимаар баталгаажуулна.



Мэдүүлгийг цахимаар мэдүүлэхтэй холбоотой зарим анхаарах асуудлууд:

1. Мэдүүлгийн бүрдүүлэлтийн <https://meduuleg.iaac.mn> програмд нэвтрэх нэр нь таны и-мэйл хаяг байх тул баталгаатай, байнга ашигладаг и-мэйл хаягийг бүртгүүлэх;
2. Таны цахимаар мэдүүлсэн мэдүүлэг нь хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл тул та нууцлалаа сайтар хамгаалах, үүний тулд мэдүүлгийн бүрдүүлэлтийн <https://meduuleg.iaac.mn> програмд нэвтрэх нууц үг, и-мэйл хаягаа бусдад алдахгүй байх, нууц үгээ шаардлагатай тохиолдолд өөрчилж байх;
3. ХАСХОМ-ийг цахим системээс хэвлэхдээ <https://meduuleg.iaac.mn> системийн “ХАСХОМ” цэснээс тухайн оны мэдүүлгээ сонгоод, “Дэлгэрэнгүй” гэсэн хэсгээс “Хэвлэх” товчийг дарж PDF файлыг хадгалж, тухайн файлыг нээж хэвлэх;
4. Хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлэхдээ байгууллагынхаа ЭБАТ-д хандаж <https://meduuleg.iaac.mn> системд их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлэх эрхээ нээлгэн, цахимаар мэдүүлж, цаасаар баталгаажуулж өгнө. Их хэмжээний өөрчлөлтийн мэдүүлгийг хэвлэхдээ мэдүүлгийн эхний мэдүүлэг гаргагчийн үндсэн мэдээллийн хуудас болон зөвхөн өөрчлөлт орсон тухайн орлого, хөрөнгө, зээлийг хэсгийг “Засварлах”-аар орж тус тусад нь хэвлэх;
5. Мэдүүлгээ цахимаар мэдүүлэхдээ мэдээллээ заавал крилл үсгээр бичих бөгөөд цахим системд өөр бусад тэмдэгтийг оруулахгүй байх. Жишээ нь: * ; “ ; / гэх мэт;
6. Мэдүүлгийн маягтын нүүрний хуудсанд байрлах “мэдүүлэг гаргах үндэслэл”-ийг зөв сонгосон байх;
7. Цахим мэдүүлгийн “Тайлан он” хэсэг нь дараах байдлаар тэмдэглэнэ. Үүнд:



- Шинэчлэн гаргасан 2014 оны ХАСХОМ- 2014
- 2015 онд шинээр томилогдоод 30 хоногтоо гаргасан ХАСХОМ-2014*
- 2015 онд хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлтөө мэдүүлсэн бол- 2014+
- Шинэчлэн гаргасан 2016 оны ХАСХОМ- 2015
- 2016 онд шинээр томилогдоод 30 хоногтоо гаргасан ХАСХОМ-2015*
- 2016 онд хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлтөө мэдүүлсэн бол- 2015+ гэх мэт.

Б. ХАСХОМ-ийг гаргахад анхаарах зарим асуудал

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг нь:

Нэг. **Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал;**

Хоёр. **Хувийн ашиг сонирхол;**

Гурав. **Хөрөнгө, орлого** гэсэн 3 үндсэн хэсгээс бүрдэнэ.

Мэдүүлэг гаргагч нь ХАСХОМ-ийн маягтыг бөглөхдөө дараах зөвлөмжийг удирдлага болгоно. Үүнд:

1. Мэдүүлгийн маягтын ерөнхий хэлбэр, асуултыг өөрчлөхгүй байх, асуулт бүрт хариулах, маягтад дурьдсан үзүүлэлтүүдээс мэдүүлэх зүйл байхгүй тохиолдолд /-/ гэж тэмдэглэнэ;
2. Мэдүүлэг гаргагч нь орлогыг мөнгөн дүнгээр илэрхийлэхдээ зөвхөн төгрөгөөр, мянгачлахгүй бичнэ;
3. Гадаад валютаар илэрхийлэгдсэн орлого, хөрөнгө, зээлийг Монголбанкны ханшаар төгрөгт хөрвүүлж мэдүүлнэ;
4. Мэдүүлгийн “Хувийн ашиг сонирхол” хэсэгт мэдүүлэг гаргагч зөвхөн өөрийн мэдээллийг бичнэ. Харин “Хөрөнгө, орлого, зээл” хэсэгт мэдүүлэг гаргагч өөрийн болон түүний “Гэр бүлийн байдал”-д бичигдсэн бүх гэр



- бүлийн нийт гишүүдийн орлого, эзэмшил, өмчлөлийн хөрөнгө, зээлийн талаар мэдүүлнэ;
5. Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн “Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд”, “Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд”, “Гишүүнчлэл, хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн” гэсэн хэсэгт “Байсан” гэдгийг сүүлийн 2 жилийн хугацаагаар ойлгоно;
 6. Хөрөнгийн үнийг бичихдээ тухайн оны зах зээлийн /бодит/ үнэлгээгээр бичнэ;
 7. Тухайн оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ажиллаж байгаа мэдүүлэг гаргагч нь “Албан тушаалтны ... оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргана. Харин дараа оны 1 дүгээр сарын 01-нээс хойш томилогдсон албан тушаалтнууд нь томилогдсоноос хойш хуанлийн 30 хоногийн дотор ... оны мэдүүлгийг гаргана.

Жишээ нь: 2016.08.01-нд томилогдсон мэдүүлэг гаргагч нь 30 хоногийн дотор “Албан тушаалтны 2015 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг гаргах бөгөөд 2015.01.01-нээс 2015.12.31-ний хооронд олсон өөрийн болон гэр бүлийн гишүүдийн нийт орлого, 2015.12.31-ний байдлаарх мэдүүлэг гаргагчийн болон гэр бүлийн гишүүдийн эзэмшил, өмчлөлийн хөрөнгийг мэдүүлнэ. /Загвар жишээ №3/

Албан тушаалтнуудын мэдүүлэгтэй танилцах

/www.xacxom.iaac.mn/

Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 196 дугаар тушаалаар баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар мэдээлэх, мэдээлэл өгөх журам”-д албан тушаалтны ХАСХОМ-ийн аль хэсэг олон нийтэд нээлттэй байх үйл ажиллагааг зохицуулсан.



Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлд “14.1 дэх хэсэгт заасан албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг тухайн оны 2 дугаар улиралд багтаан Авлигатай тэмцэх газрын мэдээллийн цахим сүлжээнд байрлуулна” гэж заасны дагуу төрийн өндөр тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуй мэдээлэлтэй www.xacxom.iaac.mn цахим хуудаснаас танилцах боломжтой.

ДОЛОО. ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН УРЬДЧИЛСАН МЭДҮҮЛЭГ ГАРГАХ

ХАСХОМ гаргах үүрэгтэй нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн болон цаашид тухайн байгууллагын зохион байгуулалтын нэгж дотроо ажлын байрны тодорхойлолт, эрхлэх асуудлын чиг үүрэгт нь өөрчлөлт орсны улмаас шилжүүлэн болон сэлгэн томилох, туршилтын хугацаагаар, Төрийн албаны тухай хуулийн хүрээнд тухайн албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохын өмнө Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /цаашид “ХАСУМ” гэх/-ийг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу гаргана.

Нэр дэвшигч нь ХАСУМ-ийн маягтыг төрийн албан хаагчийн анкетын хамт бөглөөд тухайн байгууллагын ЭБАТ-д гаргана. Байгууллагын томилох эрх бүхий удирдах албан тушаалтнаас ХАСУМ-ийг холбогдох материал /ТАХ-ийн анкет, батлагдсан ажлын байрны тодорхойлолт/-ын хамт албан бичгээр Авлигатай тэмцэх газар /Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс/-т хүргүүлнэ.

Авлигатай тэмцэх газар нь материалыг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор хянан үзэж, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилтэй эсэх асуудлаар дүгнэлт гаргах бөгөөд уг дүгнэлтийг үндэслэн байгууллагын удирдлага буюу томилох эрх бүхий албан тушаалтан нь хуульд нийцүүлэн томилгоо хийнэ.



НАЙМ. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ҮҮССЭН ЭСЭХ АСУУДЛААР МЭДЭГДЭЛ, ТАЙЛБАР ГАРГАХ

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах бөгөөд үүнийг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3 дахь хэсгийн 3.8-д нарийвчлан зохицуулсан. Үүнд:

- ашиг сонирхлын зөрчилтэй буюу зөрчил үүсч болзошгүй гэж үзвэл Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын түвшинд батлагдах шийдвэрийн төслийг боловсруулах болон шийдвэр гаргахад оролцох;
- ашиг сонирхлын зөрчилтэй буюу зөрчил үүсч болзошгүй гэж үзвэл Засгийн газар, Засгийн газрын гишүүн, яам, агентлаг, бүх шатны Засаг даргын түвшинд гарах шийдвэрийн төслийг боловсруулах болон шийдвэр гаргахад оролцох;
- төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, шалгаруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах түвшинд гарах шийдвэр, гэрээ хэлцэлийн төсөл боловсруулах болон шийдвэр гаргахад оролцох.

Дээр дурдсан тохиолдолд ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаарх мэдэгдэл, тайлбарыг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан маягтын дагуу холбогдох байгууллагын удирдлагад гаргаж, ЭБАТ бүртгэнэ.

Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд



дээрх маягтын дагуу бичгээр тайлбарыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана.

Хэрвээ ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй болон ашиг сонирхлын зөрчил үүссэн нөхцөл байдал бий болсон бол түүний шалтгааны талаар дурьдаж, уг албан үүргийг гүйцэтгэхээс албан ёсоор татгалзах нь зүйтэй.

Эрх бүхий байгууллага болон албан тушаалтан нь сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдлийг шийдвэрлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбарыг хянасны эцэст уг албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг нэн даруй бичгээр гаргана.

Албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг дараах тохиодолд зөвшөөрч болно:

- тухайн байгууллагын нэгж, эсхүл тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй, дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй;
- тухайн албан үүргийг гүйцэтгэхэд мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдах ба зөвхөн ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргасан албан тушаалтан энэ шаардлагыг хангаж байгаа бол;

Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал болон ашиг сонирхлын зөрчил үүссэн талаар гаргасан тайлбар, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэлд эрх бүхий байгууллага, албан тушаалтан нэн даруй шийдвэр гаргаагүй бол ашиг сонирхлын зөрчилгүй гэж үзсэнд тооцно.

Ийнхүү ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэхээ илэрхийлж мэдэгдэх нь Таныг уг албан үүргийг гүйцэтгэхтэй холбоотой аливаа үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчилтэй эсвэл сонирхлын зөрчилгүй болохыг нотлон харуулах баримт, нөгөө талаас авлига, ашиг сонирхлын зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлж байгаа хэрэг юм. /Загвар жишээ №1, 2/



ЗАГВАР ЖИШЭЭ №1

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны
05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ, ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Нэг. Нийтийн албан тушаалтан

Ургийн овог:	Эцэг (эх)-ийн нэр:	Нэр:
Боржигон	Балданжав	Заяажаргал
Албан тушаал: Ахлах мэргэжилтэн	Ажиллаж байгаа байгууллага: Боловсрол соёл, шинжлэх ухааны яам	
Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр: 2014.10.24	Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай, Засгийн газрын ... дугаар байр	
Албан үүргийн төрөл: Бараа, ажил үйлчилгээ худалдан авах, шалгаруулах	Тайлбар: БСШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2015.04.09-ний өдрийн А/1010 дугаар тушаалаар “Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвийн ЕБС-ийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах” үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд гишүүнээр ажилласан. Тендерын дугаар № СС-2015/05/НТШ-19	

Сонирхлын зөрчилтэй эсэх:

Тийм



Үгүй





Хоёр. Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал

Нийтийн албан тушаалтан

би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Гурав. Сонирхлын зөрчил үүссэн тухай

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх хүрээнд:

гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх /хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл/:

гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж, үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж үүрэг хүлээсэн гэх:

байгууллага, хуулийн этгээдэд ажиллаж байсан, гишүүнчлэлтэй, эсхүл төлөөлөл хэрэгжүүлж байсан /байгаа/ гэх:

Тендерт оролцож байгаа “Говийн хөгжил” ХХК-нд 2011-2013 онд менежерээр ажиллаж байсан.

Бусад /сонирхлын зөрчилтэй бусад нөхцөл байдал/:

нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчил үүссэнийг мэдэгдэж, албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж байна.



Дөрөв. Баталгаажуулалт.

Би нийтийн албан хаагчийн үүргээ чанд ухамсарлан энэхүү мэдэгдлийг үнэн зөв гаргасан болохоо үүгээр баталгаажуулж байна.

*Боловсрол соёл,
шинжлэх ухааны яамны
ахлах мэргэжилтэн*

Б.Заяажаргал

/албан тушаал/

/Гарын үсэг/

/Гарын үсгийн тайлал/

2015 оны 05 дугаар сарын 06-ны өдөр

ОГНОО

Шийдвэрлэсэн байдал

Ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрөх эсэх:

Тийм

Үгүй

Хэрэв “Тийм” бол шалтгааныг тэмдэглэнэ үү.

- Тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй
- Дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй
- Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдсан албан тушаалтан байхгүй

Баталгаажуулалт:

**Төрийн нарийн
бичгийн дарга**

Д.Батнайрамдал

/албан тушаал/

/Гарын үсэг/

/Гарын үсгийн тайлал/

2015 оны 05 дугаар сарын 07-ны өдөр

ОГНОО

**ЗАГВАР ЖИШЭЭ №2**

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны
05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ, ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Нэг. Нийтийн албан тушаалтан

Ургийн овог: <i>Хатиган</i>	Эцэг (эх)-ийн нэр: <i>Намсрайжав</i>	Нэр: <i>Батбаатар</i>
Албан тушаал: <i>Дарга</i>	Ажиллаж байгаа байгууллага: <i>Дорноговь аймгийн Замын-үүд сумын Засаг дарга</i>	
Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр: <i>2013.01.31</i>	Байгууллагын хаяг: <i>Дорноговь аймгийн Замын-үүд сум, 1-р баг</i>	
Албан үүргийн төрөл: <i>“Хяналт шалгалт зохион байгуулах тухай” 2015.09.06- ны өдрийн 258 тоот захирамж гаргах</i>	Тайлбар: <i>Дорноговь аймгийн Замын-үүд сумын төвд байрлах согтууруулах ундаагаар үйлчилдэг, тус сумын Засаг даргын 2015.09.06-ны өдрийн 258 тоот захирамжийн хавсралтад дурдагдсан хяналт шалгалтад хамрагдах аж ахуй нэгж байгууллагуудтай ашиг сонирхлын зөрчилгүй болно.</i>	

Сонирхлын зөрчилтэй эсэх:

Тийм

Үгүй



